



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ УЛС
ТӨРИЙН НАМ БОЛОН БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ НАРТ

2024.03.25 № 08/796
танай _____-ны № _____-т

Хандивын тайлангийн маягт хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсэгт "Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын эхний долоо хоногт багтаан энэ хуулийн 38.13-т заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ" гэж заасан.

Энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхээр "Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар"-ыг Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/24 дүгээр тушаалаар баталсан.

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.7-д заасан хандивын тайланг "Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт зааврын хавсралт МАЯГТ 1, 2-ын дагуу 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 17:30 цагийн дотор Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.

Хандивын тайланг үнэн зөв, холбогдох мэдээллийг бүрэн тусгасан байдлаар хуульд заасан хугацааны дотор, дүгнэлт гаргахад шаардлагатай дараах баримт бичгийг нотлох баримтын шаардлага хангасан хэлбэрээр битүүмжлэн ирүүлнэ үү. Үүнд:

- Намын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Намын 2023 оны санхүүгийн жилийн эцсийн аудитлагдсан тайлан,
- Харилцагч банкны баталгаажуулсан дансны хуулга (2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31, 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх), банкны тодорхойлолт (данс бүрээр),

Бие даан нэр дэвшигчийн хувьд УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулиуд нэр дэвшиж Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4-т заасны дагуу нээлгэж, бүртгүүлсэн зардлын дансанд нэр дурдсан хугацаанд хандив авсан бол дүгнэлт гаргуулах шаардлагатай болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт заасны дагуу хандивын тайланд дүгнэлт гаргах бөгөөд намын дүрэм, дотоод үйл ажиллагаанд зориулан намын гишүүний өгсөн татвар, хандивыг хамруулахгүй.


Нам, эвслээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд аливаа байдлаар тусгагдаагүй орхигдсон эсхүл мэдээлээгүй хандивыг Үндэсний аудитын газар хариуцахгүй болно.

Жич: Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын 261729 дугаарын утсаар холбогдож лавлагаа мэдээлэл авах боломжтой бөгөөд дансны хуулга, МАЯГТ 1,2 -г EXCEL хэлбэрээр shurentsetsegt@audit.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт 2 хуудастай

ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ЭНХБОЛД



Ням, зөслэс ирүүлсэн хандивын тайланг хөн баталгаажуулж, дүгнэлт гаргах з. аврын ивэсрө

МАЯГТ

УИХ-ын ээлжит /ээлжит бус, нөхөн/ сонгуульд оролцох нам, зөсэлд "ИРГЭН"-ээс өгсөн хандивын дэлгэрэнгүй жагсаалт

.....нам, ээслийн нэр

Д/д	Овог, нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл						Хандив өгсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан		МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 54.4-т заасан хандив мэдээллийн шаардлага хандивыг буцаан шилжүүлснээс				Тайлбар
		Иргэний бүртгэлийн дугаар	Нас	Иргэншил	Хандивын эх үүсвэрийн мэдээлэл	Оршин суугаа хаяг	Утасны дугаар			Банкны нэр	Дансны дугаар	/Тийм, үгүй/	Тийм бол мөнгөн дүн	Хандивыг буцаасан дансны дугаар	Бүтэц хаяг тодорхойгүй хандивыг улсын орлого буюу төрийн санд шилжүүлсэн тохиолдолд огноо, дансны дугаар бичих	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	
1								2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрийг дотор								
2																
1								2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг дотор								
2																
3																

Санамж: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.13-т заасан хугацаанд мөн хуулийн 54, 55 дугаар зүйлд заасан хандивыг хамгааруулан дүгнэлт гаргана. Харин намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан намын гишүүний өгсөн хандивыг хамруулахгүй болно.

Тэмгэ, тэмдэг

Хянасан:

Албан тушаал овог нэр гарын үсэг

Боловсруулсан:

Албан тушаал овог нэр гарын үсэг

УИХ-ын ээлжтэй /ээлжит бус, нөхөн/ сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчид "ХУУЛИЙН ЭТГЭЭД"-ээс өгсөн хандивын дэлгэрэнгүй жагсаалт

МАЯГТ-2

... нам, эвслийн нэр

(Төгрөгөөр)

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл						Хандив хүлээн авсан			Хандивын мөнгөн дүн	МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 54.4-т заасан хандивын мэдээллийн шаардлага хангаггүй хандивыг буцаан шилжүүлсэн зсэх				Тайлбар
		Регистрийн дугаар	Хандивын эх үүсвэрийн мэдээлэл	Хаяг, утасны дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Үйл ажиллагааны чиглэл	Хариуцлагын хэлбэр	Огноо	Банкны нэр	Дансны дугаар		Тийм, Үгүй!	Тийм бол мөнгөн дүн	Хандивыг буцаасан дансны дугаар	Буцах хаяг тодорхойгүй хандивыг улсын орлого буюу төрийн санд шилжүүлсэн тохиолдолд огноо, дансны дугаар бичих	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1																
2																
1																
2																
3																

Санамж: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.13-т заасан хугацаанд мөн хуулийн 54, 55 дугаар зүйлд заасан хандивыг хамааруулан дүгнэлт гаргана. Харин намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан намын гишүүний өгсөн хандивыг хамруулахгүй болно.

Тамга, тэмдэг

Хянасан:

Албан тушаал

овог нэр

гарын үсэг

Боловсруулсан:

Албан тушаал

овог нэр

гарын үсэг